“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК

# “БИ ДИ СЕК ҮЦК” ХК
# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2022 оны 12 сарын 31-нээр дуусгавар болгосон аудитын тайлан

Улаанбаатар хот

2023 он

# "БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН 2022 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА ХУУДАС


Удирдлагын хариуцлагын мэдэгдэл.........2

Хараат бус аудиторын тайлан ..............3-5

Санхүүгийн байдлын тайлан ….................6

Орлогын тайлан ......................................7-8

Мөнгөн гүйлгээний тайлан …....................9-10

Өмчийн өөрчлөлтийн тайлан ..............11

Санхүүгийн тайлангийн тодруулга, компанийн товч мэдээлэл, танилцуулга ......................................................................12-14

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй …...........................................15-21

Санхүүгийн тайлангийн тодруулга ......................................................................22-28


**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл даараах хаягаар харилцана уу.**


Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг
Утас: 976-7013-1770
Гар утас: 9511-1770

Аудитор:З.Алтантуяа
Гар утас: 9511-1770
Туслах аудитор: Т.Мөнхцацрал
Утас:97111770

Чанарын хяналтын аудитор
Б.Бямбасүрэн
Гар утас: 99184746

Аудиторын туслах Д.Амгалан
Т.Энхсайхан

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нарны зам 81, JS tower 1002 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

**Вэб хуудас:** www.pma.mn


2023 оны 04 дугаар сарын 03

**2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 5-8 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Би Ди Сек ҮЦК” ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, “Их Чингис Хааны хөмрөг” ХХК-ын нэгтгэсэн санхүүгийн “ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь харуулах зорилгоор хийгдсэн болно.

Компаний удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа СТОУС, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Би Ди Сек ҮЦК” ХК-ний 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

| Д.Даянбилгүүн | Б.Лхагвадорж | Д.Даваасүрэн |
|---|---|---|
| Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга | Ерөнхий Захирал | Ерөнхий Нягтлан Бодогч |

Улаанбаатар хот, Монгол улс
2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр

PANTHER MIDLAND AUDIT LLC
AUTHORIZED EXPERTS IN ACCOUNTING, AUDIT, CONSULTATION AND ASSESSMENT

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо : 2023.04.03 № 23/20

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

## Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 12-28 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

## Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна..

## Бусад мэдээлэл

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалтай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Номинал дансны талаар**

"Би Ди Сек ҮЦК" ХК нь өөрийн харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий Худалдаа Хөгжлийн банканд байрших, 452644001 ам долларын, Голомт банканд байрших 1105391344 тоот ам долларын данс, Голомт банкны 1105057130 тоот төгрөгийн номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

**"Пантер Мидланд Аудит" ХХК**
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

УЛААНБААТАР ХОТ
ПАНТЕР МИДЛАНД АУДИТ ХХК
1118261632
5103614 СБТ1854

PANTHERE MIDLAND AUDIT LLC
AUTHORIZED EXPERTS IN ACCOUNTING, AUDIT, CONSULTATION AND ASSESSMENT

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2023.04.04 № 23/40

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК -д**

**Тайлан хүргүүлэх тухай**

Бид танай байгууллагын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж дуусгавар болгосон тайлан хүлээлгэн өгч байна.

Та бүхэн танилцаад санал хүсэлт байвал бидэнд ирүүлнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.АЛТАНЦЭЦЭГ

УЛААНБААТАР ХОТ
ПАНТЕРЕ МИДЛАНД АУДИТ ХХК
1118261632
5103614 СБТ 1854

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

### "БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(төгрөгөөр)

| Дансны нэрс | 1/1/2022 | 12/31/2022 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,774,085,785.81 | 2,660,936,353.93 |
| Дансны авлага | 3,080,017,817.80 | 3,127,553,537.25 |
| Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | 0.00 |
| Бусад авлага | 1,655,549.52 | 1,645,549.52 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 14,776,608,152.02 | 0.00 |
| Холбоотой талаас авах авлага | 0.00 | 760,826,678.04 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 17,501,555.85 | 133,059,243.46 |
| Ажилчдаас авах авлага | 0.00 | 240,267,518.50 |
| Арилжааны үнэт цаас | 0.00 | 26,172,741,305.45 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **19,649,868,861.00** | **33,097,030,186.15** |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 4,414,284,292.26 | 4,381,510,296.20 |
| Биет бус хөрөнгө | 12,547,914.53 | 40,864,320.60 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 51,000,000.00 | 51,000,000.00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **4,477,832,206.79** | **4,473,374,616.80** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **24,127,701,067.79** | **37,570,404,802.95** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 4,475,086,457.80 | 1,156,799,486.23 |
| Цалингийн өглөг | 157,518,711.83 | 40,409,163.52 |
| Орлогын татварын өглөг | 105,219,035.54 | 166,845.07 |
| ХАОАТ-ын өглөг | 35,712,629.52 | 20,865,477.25 |
| ҮХХТ-ын өглөг | 6,938,400.00 | 3,469,200.00 |
| НӨАТ өглөг | 1,964,058.36 | 939,882.18 |
| Урьдчилж орсон орлого | 242,236.57 | 477,871.19 |
| Векселийн өглөг | 2,535,395.78 | 377,938,477.04 |
| Нөөц (өр төлбөр) | 41,084,649.00 | 41,084,649.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 500,000,000.00 | 999,831,700.91 |
| Бусад өглөг /Номинол/ | 676,844,383.70 | 168,584,869.68 |
| ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | 36,953,177.69 | 24,438,131.88 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **6,040,099,135.79** | **2,835,005,753.95** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Урт хугацаат зээл | 0.00 | 20,592,499,677.94 |
| Нөөц (өр төлбөр) | 0.00 | 0.00 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **0.00** | **20,592,499,677.94** |
| Нийт өр төлбөр | **6,040,099,135.79** | **23,427,505,431.89** |
| **Эзэмшигчдийн өмч** | | |
| Өмч: - төрийн | 0.00 | 0.00 |
| - хувийн | 1,369,488,300.00 | 1,369,488,300.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | 7,957,309,291.00 | 7,957,309,291.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,824,524,382.82 | 3,824,524,382.82 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 0.00 | (600,193,925.70) |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 4,936,279,958.18 | 1,591,771,322.94 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **18,087,601,932.00** | **14,142,899,371.06** |
| **НИЙТ ӨМЧ, ӨР ТӨЛБӨР** | **24,127,701,067.79** | **37,570,404,802.95** |

*12-28 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

# АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
## "БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(төгрөгөөр)

| № | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | | | |
| **1.1.1** | **Үйл ажиллагааны орлого:** | **3,378,231,351.10** | **2,467,961,884.26** |
| 1.1.1.1 | Брокерийн үйл ажиллагааны | 474,456,408.67 | 209,782,656.24 |
| 1.1.1.2 | Андеррайтерийн үйл ажиллагааны | 1,790,585,270.67 | 1,844,881,146.17 |
| 1.1.1.3 | Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний | 354,630,042.10 | 20,716,112.92 |
| 1.1.1.4 | Үнэт цаасны арилжааны цэвэр орлого | 758,559,629.66 | 392,581,968.93 |
| **1.1.2** | **Хөрөнгө оруулалтын орлого** | **332,566,552.54** | **995,780,700.00** |
| 1.1.2.1 | Компанийн бондын хүүгийн орлого | 0.00 | 544,518,046.92 |
| 1.1.2.2 | Ногдол ашгийн орлого | 179,786,251.83 | 149,583,739.36 |
| 1.1.2.3 | Бусад орлого | 42,967,285.26 | 141,531,542.80 |
| 1.1.2.4 | Түрээсийн орлого | 109,813,015.45 | 160,147,370.92 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | **3,710,797,903.64** | **3,463,742,584.26** |
| **1.2** | **Борлуулсан хөрөнгө оруулалтын үнэт цаасны өртөг** | **0.00** | **0.00** |
| **1.3** | **Нийт ашиг /алдагдал/** | **3,710,797,903.64** | **3,463,742,584.26** |
| **1.4** | **Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирддлага/-ын зардал** | | |
| 1.4.1 | Үндсэн болон нэмэгдэл цалин | 776,627,722.04 | 996,306,126.50 |
| 1.4.2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 91,071,727.15 | 123,947,781.87 |
| 1.4.3 | Засвар үйлчилгээний зардал | 23,669,089.07 | 142,162,351.91 |
| 1.4.4 | Ашиглалтын зардал /интернет, түрээс/ | 71,480,312.64 | 114,450,735.92 |
| 1.4.5 | Сургалтын зардал | 2,421,000.00 | 7,139,000.00 |
| 1.4.6 | Албан томилолтын зардал | 20,173,540.00 | 5,261,659.00 |
| 1.4.7 | Бичиг хэргийн зардал | 17,789,632.35 | 44,951,160.00 |
| 1.4.8 | Тээврийн зардал | 498,000.00 | 540,500.00 |
| 1.4.9 | Шатахууны зардал | 18,298,681.00 | 24,179,647.00 |
| 1.4.10 | Аж ахуй хангамжийн материалын ззардал | 52,695,280.96 | 0.00 |
| 1.4.11 | Элэгдлийн зардал | 160,890,698.76 | 157,739,709.28 |
| 1.4.12 | Зар сурталчилгааны зардал | 84,265,345.00 | 88,082,917.25 |
| 1.4.13 | Шуудан холбооны зардал | 11,051,874.39 | 30,733,794.22 |
| 1.4.14 | Шагнал урамшууллын зардал | 4,252,900.00 | 0.00 |
| 1.4.15 | Зээлийн хүүгийн зардал | 401,080,371.22 | 1,147,185,685.19 |
| 1.4.16 | Бусад татварын зардал | 15,869,344.00 | 0.00 |
| 1.4.17 | Хөндлөнгийн хяналт шалгалтын зардал | 0.00 | 14,485,350.00 |
| 1.4.18 | Харуул хамгаалалтын зардал | 21,900,000.00 | 22,932,000.00 |
| 1.4.19 | Даатгалын зардал | 1,902,790.00 | 2,151,890.00 |
| 1.4.20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал | 205,006,492.68 | 0.00 |
| 1.4.21 | Үнэт цаасны арилжааны зардал | 338,094,630.06 | 444,323,103.00 |
| 1.4.22 | Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал | 34,899,727.00 | 39,929,167.84 |
| 1.4.23 | Бусад зардал | 48,193,222.00 | 0.00 |
| 1.4.24 | Зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс | 0.00 | 0.00 |
| 1.4.25 | Сонин сэтгүүл захиалгын зардал | 0.00 | 148,000.00 |
| 1.4.26 | Түрээсийн зардал | 0.00 | 7,580,000.00 |
| 1.4.27 | Бусад санхүүгийн зардал | 0.00 | 15,050,000.00 |
| 1.4.28 | Шимтгэл хураамжийн зардал МХБ | 59,910,601.76 | 33,112,957.40 |
| 1.4.29 | Шимтгэл хураамжийн зардал ҮЦТХТ | 26,252,046.81 | 11,323,185.98 |
| 1.4.30 | Шимтгэл хураамжийн зардал СЗХ | 7,124,613.47 | 6,669,167.64 |
| | *Гишүүнчлэлийн хураамж* | | 19,800,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.4.31 | Бусад шимтгэл | 20,027,402.90 | 92,403,308.09 |
| **1.4.32** | **Үйл ажиллагааны зардлын дүн** | **2,515,447,045.26** | **3,592,589,198.09** |
| **1.5** | **Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | **1,195,350,858.38** | **(128,846,613.83)** |
| 2 | **Үндсэн үйл бус үйл ажиллагааны ашиг (алдагдал )** | 0.00 | 0.00 |
| 2.1.1 | **Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)** | (55,000.00) | 0.00 |
| 2.1.2 | Хүүгийн орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.3 | Хүү торгууль, хөнгөлөлтийн орлого | 111,592.79 | 0.00 |
| 2.1.4 | Хандив тусламжийн орлого | | |
| 2.1.5 | Бусад орлого | 390,000.00 | 0.00 |
| 2.1.6 | Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 11,139,479.76 | 15,812,500.29 |
| 2.1.7 | Валютын ханшийн зөрүүгийн гарз | | (983,985,467.65) |
| 2.1.8 | Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал) | (1,034,606.20) | (13,353,206.17) |
| 2.1.9 | Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал) | 307,617,872.20 | 0.00 |
| 2.1.10 | Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн олз | 253,124,968.38 | (2,232,184,089.07) |
| 2.1.11 | Хувьцаа, бондын зардлын хорогдуулга | | |
| 2.1.12 | Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг | | |
| 2.1.13 | Хандив тусламжийн зардал | (6,000,000.00) | (1,800,000.00) |
| 2.1.14 | Бусад зардал | (3,099,270.00) | 0.00 |
| 2.2 | Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдлын дүн / | **562,195,036.93** | **(3,215,510,262.60)** |
| 3 | **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **1,757,545,895.31** | **(3,344,356,876.43)** |
| 3.1 | **Орлогын татварын зардал** | 123,017,060.68 | 151,758.81 |
| 4 | **Татварын дараахь ашиг /алдагдал/** | **1,634,528,834.63** | **(3,344,508,635.24)** |
| 4.1 | **Цөөнхөд ноогдох хувь** | 0.00 | 0.00 |
| 5 | **Ердийн ажиллагааны ашиг / алдагдал/** | **1,634,528,834.63** | **(3,344,508,635.24)** |
| 5.1 | **Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)** | 0.00 | 0.00 |
| 6.0 | **Тайлант үеийн цэвэр үр дүн** | **1,634,528,834.63** | **(3,344,508,635.24)** |

*12-28 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

## АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Дахин үнэлгээний нөөц | Нэмж төлөгдсөн капитал | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **3,824,524,382.82** | **7,957,309,291.00** | **0.00** | **3,301,751,123.54** | **16,453,073,097.36** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **Залруулсан үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 1,634,528,834.64 | **1,634,528,834.64** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **3,824,524,382.82** | **7,957,309,291.00** | **0.00** | **4,936,279,958.18** | **18,087,601,932.00** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | (2,977,265.70) | 0.00 | **(2,977,265.70)** |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **3,824,524,382.82** | **7,957,309,291.00** | **(2,977,265.70)** | **4,936,279,958.18** | **18,084,624,666.30** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | (3,344,508,635.24) | **(3,344,508,635.24)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | (597,216,660.00) | 0.00 | **(597,216,660.00)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488,300.00** | **3,824,524,382.82** | **7,957,309,291.00** | **(600,193,925.70)** | **1,591,771,322.94** | **14,142,899,371.06** |

*12-28 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.*

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## "БИ ДИ СЕК ҮЦК" ХК

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **2,659,637,710.56** | **3,659,612,946.55** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 2,475,527,866.60 | 3,659,015,210.51 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,783,200.00 | 0.00 |
| Хүлээн авсан ногдол ашиг | 179,786,251.83 | 0.00 |
| Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| Бусад мөнгөн орлого | 2,540,392.13 | 597,736.04 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **(1,334,217,265.27)** | **10,678,919,535.02** |
| Ажиллагчдад төлсөн | (569,742,839.57) | (895,380,935.38) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (153,425,107.00) | (233,954,081.54) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 4,359,167,712.50 | 13,530,701,941.31 |
| Ашиглалтын зардалд төлсөн | (88,163,370.48) | (100,987,985.97) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (8,291,900.82) | (4,204,061.00) |
| Хүүний төлбөрт төлсөн | (402,392,401.47) | (747,394,340.52) |
| Татварын байгууллагад төлсөн | (85,285,296.24) | (220,555,911.58) |
| Даатгалын төлбөрт төлсөн | (1,902,790.00) | (2,151,890.00) |
| Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжинд төлсөн | (41,922.19) | |
| Бусад мөнгөн зарлага | (4,384,139,350.00) | (647,153,200.30) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,325,420,445.29** | **14,338,532,481.57** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | 0.00 | 0.00 |
| Мөнгөн орлогын дүн (+) | **7,921,637,716.32** | **4,420,145,106.10** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 9,700,000.00 |
| Биет бус хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого | 7,921,576,935.57 | 4,410,445,106.10 |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан олголт | 60,780.75 | 0.00 |
| Хүлээн авсан хүүний орлого | 0.00 | |
| Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **1,442,195,311.19** | **16,932,582,619.00** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 29,645,356.00 | 48,286,049.00 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (30,080,076.00) | 16,848,897,834.75 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа | 1,442,630,031.19 | 35,398,735.25 |
| Ханшийн тэгшитгэлийн ашиг | 0.00 | 0.00 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **6,479,442,405.13** | **(12,512,437,512.90 )** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **35,726,647,565.74** | **25,842,856,386.89** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан | 4,994,499,659.62 | 11,575,850,591.66 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан | 30,655,431,014.78 | 14,241,567,082.11 |
| Бусад мөнгөн орлого | 82,716,891.34 | 27,238,713.12 |
| Төрөл бүрийн хандив | (6,000,000.00) | (1,800,000.00) |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **42,314,108,587.41** | **26,782,100,787.44** |

| | | |
|---|---:|---:|
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 11,793,805,296.86 | 11,185,249,067.05 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 30,437,466,233.75 | 14,992,553,969.58 |
| Төлсөн ногдол ашиг | 0.00 | 597,216,660.00 |
| | 0.90 | 24,717.22 |
| Ханшийн зөрүүний алдагдал | 82,837,055.90 | 7,056,373.59 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(6,587,461,021.67)** | **(939,244,400.55)** |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,217,401,828.75** | **886,850,568.12** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **556,683,957.06** | **1,774,085,785.81** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,774,085,785.81** | **2,660,936,353.93** |